

“ХЭРЛЭН ХИВС” ХХК-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ТАЙЛАН

Хэрлэн сум

“Хэрлэн хивс” ХК нь 1989 онд ашиглалтад орж улсын хэмжээнд 21 аймаг, хотод 10,000 гаруй хувьцаа эзэмшигчтэй. Жилд 650,000 метр квадрат хивс нэхэх хүчин чадалтай, 700 гаруй ажилтан, 80 гаруй инженер техникийн ажилтантай, монгол улсдаа хамгийн сүүлийн үеийн техник тоног төхөөрөмжөөр тоноглогдсон үйлдвэр байсан.

Австрийн түүхийн эдийн зээлийн төлбөрийг төлж чадаагүйн улмаас 1997 онд Хивсний үйлдвэрийн үйл ажиллагаа зогссон. Уг Австрийн өр нь зах зээл эхлэхээс өмнө Засгийн газар хоорондын хэлэлцээрээр байгуулагдсан ба уг гэрээг хивсний үйлдвэрүүдийг төлөөлж “Ноос импекс” ферм алдагдалтай, зээлийн хүү өндөр гэрээг хийсэн. Зээлийг Худалдаа үйлдвэрийн Яам, Сангийн Яам өр барагдуулах ажлыг хийх ёстой байтал уг өрийн талаар мэдээлэл дээрхи яамдууд дээр холбогдох материал усгагдсан, зээлийг ХХБанк төлсөн гэх боловч тухайн материал Сангийн яам, Монгол банканд байхгүй байна. Энэ талаар Сангийн Яам, Монгол банк Төрийн өмчийн Хороонд хандсан боловч холбогдох материал алга байна гэсэн хариуг өгсөн. ХХБанк Австрийн банктai хийсэн гэрээг харахад уг зээлийг төлөх ямар ч үүрэг хүлээгээгүй байдаг. ХХБанкыг хувьчлагдах үеийн тайланг харахад Австрийн өрийг Засгийн газар хоорондын хэлэлцээрээр 30%- ыг хүчингүй болгосон гэж бичигдсэн байна. Гэтэл энэ талаар Австрийн өрийг шийдвэрлэсэн тухай ганц ч материал олдохгүй, тухайн өрийг төлсөн гэх ХХБанкны өр хаасан материал огт байхгүй байсан. Сангийн Яамнаас ХХБанканд уг өрийг хэрхэн барагдуулсан талаар тайлбар авах гэсэн боловч тухайн үеийн баримт нотолгоо устгагдсан гэсэн хариу өгсөн.

Австрийн зээлийг компаний бүх гишүүдийн хурлаар хэлэлцэх ёстой байсан боловч огт хэлэлцэгдээгүй манай компанд хамааралгүй өр байсан. Иймд 2014 оны Хувьцаат компаний хурлаар уг өрийн талаар тайланг албан ёсоор тавихыг компаний удирдлага хурлаас сонгогдсон ажлын хэсэгт үүрэг болгосон.

1. Дорнод аймгийн Шүүхийн 1998 оны 4 дүгээр сарын 09-ны №02 тоот шийдвэр, “Хэрлэн Хивс” ХК-аас 28929508 шиллинг 1991оны 12 дугаар сарын ханшаар буюу 280 сая төгрөгийг Худалдаа хөгжлийн Банканд олгох шийдвэр гарсан.
2. Гэтэл Улсын дээд шүүхийн 1998 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн № 98 тоот шийдвэр Худалдаа хөгжлийн Банканд Австрийн түүхий эдийн өр болох 1 876 898 469 \1998 оны Австрийн шиллингийн ханшаар/ төгрөгийг “Хэрлэн Хивс” ХК гаргуулахаар шийдвэрлэж “Хэрлэн Хивс” ХК -ны эрх ашгийг санаатайгаар хохироосон. Яг манай компантай адил Улаанбаатар Хивсний үйлдвэрийн Австрийн өрийг 1997 онд зээл авч байх үеийн ханшаар буюу 1992 оны зах зээлийн ханшаар шийдвэрлэсэн байсан. Ийм зөрүүтэй шийдвэрийг Улсын Дээд Шүүх гаргаж байсан.

Уг Австрийн зээлийн “Ноос импекс” фирм Хивсний үйлдвэрүүдийн өмнөөс Австри Монголын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу түүхий эдийг “Ноос Импекс” ферм гэрээ байгуулж авсан байдаг. Австрийн “Ламбахер Хитиаг” компанаас мяндсан

хөвөн утас вискоз, капрон зэрэг түүхий эдийн үнэ болох нийт 140 сая австри шиллингийн бараа бүтээгдэхүүн авсан.

Уг зээлийн гэрээг Худалдаа хөгжлийн Банк Засгийн газрыг төлөөлөн Австрийн засгийн газрыг төлөөлж Керидетанштальт банканд мөнгө шилжүүлэх зээлийн гэрээ хийсэн. Уг гэрээнд Худалдаа хөгжлийн Банк 140 сая төгрөгийн зээлийг Хивсний үйлдвэрүүдийн өмнөөс төлөх үүрэг хүлээгээгүй байна.

Хавсралт тодруулга.

1997 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн №84 тоот шийдвэр, Улаанбаатар хивснээс Худалдаа хөгжлийн Банканд Австрийн өрийн зээл авсан үеийн ханшаар /1992 оны ханшаар/ 22,9 сая австри шиллинг гаргуулах шийдвэрийг Улсын дээд шүүхийн 1997 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн №84 тоот магадлалаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн байна. Гэтэл манай компаний дээд шүүхийн Австрийн өрийг шийдсэн шийдвэр нь шүүхэд хандсан үеийн 1998 оны ханшаар буюу 1,8 тэр бум төгрөг гарсан. Гэтэл “Эрдэнэт Хивс” ХК үйлдвэрийн австрийн үеийн өрийг “Эрдэнэт Хивс” ХК-ны хувьцааны 18 %-ийг Худалдаа хөгжлийн Банкны мэдэлд авсан. Зарчим нь ийм байдлаар шийдвэрлэх байтал “Хэрлэн Хивс” ХК-ны хувьцаа эзэмшигчдийн өмчид хууль бусаар халдсан луйвар хийсэн байна.

Энэ байдлаас харахад Улсын дээд шүүх яг адил хэмжээний өртэй нэг нөхцөлтэй гэрээг 2 өөр шийдвэр гаргасан нь шүүх илт тэгш бус хандаж байгаа нь үүнээс тод харагдаж байна.

- Уг Австрийн зээл нь засгийн газар хоорондын хэлэлцээрээр явагдсан Сангийн Яам, Худалдаа үйлдвэрийн Яам хариуцаж байсан байна.
- 1992 онд улсын үйлдвэрийн газар хувьчлагдах үед уг өрийн талаар Хувьцаа эзэмшигчдэд огт мэдэгдээгүй “Хэрлэн Хивс” ХК-ийг хувьчлах тайландаа оруулаагүй байдаг. Үүнтэй холбоотой баримт тооцоо хүртэл олдохгүй байгаа.

Улсын дээд шүүхийн 1998 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 98 тоот шийдвэрийн дагуу Дорнод аймгийн ШШГА-аас 1999 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 2,957,7 сая төгрөгийн хөрөнгийг битүүмжилж улмаар тэр өдөр 2,957,7 сая төгрөгийг хөрөнгийг хураасан акт үйлдэж ШШГ Албаны эзэмшилд өгсөн.

Компаний тухай хуулинд их хэмжээний хэлцэлийг бүх гишүүдийн хурлаар заавал оруулдаг ба хувьцаа эзэмшигчдийн хурлаар ороогүй хэлцэлийн хариуцлагыг хувьцаа эзэмшигчид хариуцах ёсгүй.

Гэтэл Дорнод аймгийн ШШГ Алба, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгөнд халдан 1999 оны 12 дугаар сарын 02-ны өдөр 1998 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн Улсын Дээд шүүхийн № 98 тоот шийдвэрээр бараг бүх хөрөнгийг Худалдаа хөгжлийн Банканд шилжүүлсэн акт үйлдэн тооллого хийн хураан авсан.

1999 оны 12 дугаар сарын 02-ны өдөр хураан авсан хөрөнгийн хавтаст хэрэгт үйлдвэрийг цаашид ажиллуулах менежментийн төлөвлөгөө боловсруулах үүргийг “Хэрлэн Хивс” ХК-ийн удирдлагтай хамтран тохиролцон тэмдэглэл үйлдсэн байна. /1999-02-03-ны өдөр/

“Хэрлэн Хивс” ХК-ийн хөрөнгийг 1997 оны 5 дугаар сарын 29-ны өдөр хөрөнгийн үнэлгээний “ПРАЙС.” төвөөр үнэлүүлж /2,87 тэр бум төгрөг/ социализмын үеийн/ үнэлгээгээр ХХбанканд шилжүүлсэн. Гэтэл уг үнэлгээг ШШГ алба дахин үнэлгээ хийхгүй

шууд авсан нь “Хэрлэн Хивс” ХК-ын өмчийг хэт үнэгүйдүүлсэн. Жишээ нь: Уг үнэлгээнд складанд байгаа шинэ насос K90/35, K45/55 марк насосыг 200 төгрөгөөр авсан байна.

1999 онд бууз 100 төгрөг байсан. Ийм байдлаар үнэлгээ хийн өрөндөө хураасан. Тухайн гүйцэтгэлийн ажиллагаанд “Хэрлэн Хивс” ХК-ын гүйцэтгэх захирал Г. Энхбаатар оролцоогүй учир нь луйварын аргаар үйлдвэрийг үнэгүйдүүлж байна гэж үзэн оролцохоос татгалзсан.

ХХБанкнаас “Хэрлэн Хивс” ХК-нд 2005 онд албан бичиг ирсэн. Тус албан бичигт үлдсэн хөрөнгөө ав бид харуул хамгаалалтын хөлс тооцох болно гэсэн. Уг албан бичгийн хариуг 2005 оны 08 дугаар 26 -ны өдөр ХХБанканд хариу албан бичигтээ харуул хамгаалалтын хөлс зардалыг тодорхой болгох шаардлагтай байна гэсэн хариу өгсөн. Үүнээс харахад Худалдаа хөгжлийн Банк манай өмчийг бүрэн хариуцаж байсан гэдэг нь харагдаж байна.

ШШГ Алба манай хөрөнгийг бүгдийг хураан аваад Худалдаа хөгжлийн Банканд хүлээлгэн өгч манай компанд үлдэх хөрөнгийг албан ёсоор тухайн үеийн удирдлагад хүлээлгэн өгөөгүй. Бид ямар өмч үлдсэнээ мэдэхгүй, зөвхөн сургаар хэдэн нэхэх машин үлдсэн гэх мэдээлэл авсан.

“Хэрлэн Хивс” ХК 2005 оны 07 дугаар сарын 20-ны өдөр хуралдаж Д. Ганцогт миний бие гүйцэтгэх захиралаар томилогдсон. Тухайн үед ямар өмч эсэх, үлдсэн өмчөө яаж авах талаар Худалдаа хөгжлийн Банканд хандсан боловч хариу өгөөгүй. Үйлдвэрийн өмч Худалдаа хөгжлийн Банкны харуул хамгаалалттай байгааг мэдсэн.

Миний бие өмнөх гүйцэтгэх захирал байсан Г. Энхбаатар нябо Дамидмаа нараас өмч хөрөнгийн талаар тодорхой баримт бичиг аваагүй бүх материал Худалдаа хөгжлийн Банкны хамгаалалтад байгаа тухай мэдээлэл авсан. Гэтэл 2006 онд “Эрдэнэт Хивс” ХХК манай машинуудыг ачиж тоноод зөөж байгаа гэсэн мэдээлэл аваад Дорнод аймгийн ШШГ Албаны ахлах шийдвэр гүйцэтгэгч Гомбодоржтой уулзаж 1999 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хавтаст хэрэгтэй танилцсан. Худалдаа хөгжлийн Банканд шилжүүлж үлдээсэн өмч хөрөнгө салгаж үлдээсэн ШШГүйцэтгэлийн тэмдэглэлд Ээрэх нэхэх үйлдвэрийн конторын барилга, захиргааны барилгын баруун зүүн жигүүрийн барилга үлдээсэн тухай /4 тусдаа барилга/ мэдээлэл авсан. Өөр өмч хөрөнгө үлдээсэн ямар нэг баримт байгаагүй. Уг хавтаст хэрэгт Худалдаа хөгжлийн Банканд 12 ширхэг “ТЕХТИМА 4312” маркийн машин шилжүүлсэн баримтыг үндэслэн нийт 23 машинаас 11 ширхэг машин үлдсэн тооцоо гаргаж 1995 онд тоногдсон 11 ширхэг машин, үлдсэн хөрөнгө болох 4 хэсэг барилгаа өмчлөл тогоолгохоор Дорнод аймгийн иргэний шүүхэд нэхэмжлэл гаргасан.

2005 онд “Эрдэнэт Хивс” ХК 2004 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн № 2030314 20/121 V- 0611003485 үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээнд 190*375 хэмжээтэй 7 га талбай бүхий объект эд хөрөнгийн хашаа бүхэлд нь авсан тухай мэдээлэлийг 2005 онд авсан. Бидэнд энэ тухай мэдээллийг Худалдаа хөгжлийн Банкнаас албан ёсоор мэдэгдээгүй бид үйлдвэрийг цаашид зээл авч ажиллуулж явна гэсэн тохиролцоо нөхцөлтэй байсан. Худалдаа хөгжлийн Банк өмч хөрөнгийг тоногдохоос хамгаалж цаашид үйлдвэрийг ажиллуулж байж зээлийг барагдуулна гэдэг байдлаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны хавтас хэрэгт тэмдэглэгдсэн байдаг. Худалдаа хөгжлийн Банк “Хэрлэн Хивс” ХК-ны өмч хөрөнгөнд халдана гэж огт бодоогүй байсан. Хэрэв өрөнд авах тохилдолд хувьцааг авах ёстой байсан.

Миний бие “Хэрлэн Хивс” ХК-ны хувьцаа эзэмшигчийн хувьд өмч хөрөнгөө Худалдаа хөгжлийн Банкнаас өөрийн эзэмшилд “Эрдэнэт Хивс” ХК-д шилжсэн гэж дуулсан. Улмаар Дорнод аймгийн Захиргааны хэргийн шүүхэд V- 0611003485 үл хөдлөх

хөрөнгийн гэрчилгээг хүчингүй болгуулахаар хандаж 2005 оны 04 дүгээр сарын 27-ны №03 шийдвэрээр хүчингүй болгуулсан.

Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүхээр 2005 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн №31 тогтоолоор Дорнод аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.

2004 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Худалдаа хөгжлийн Банк “Эрдэнэт Хивс” ХК-тай 68/2004 дугаар бүхий худалдан авах гэрээ байгуулж 200,000,000 сая төгрөгөөр худалджээ. “Хэрлэн Хивс” ХК- буюу үйлдвэр ажиллаж байх үед ХХбанк 1995 оны 2 дугаар сарын 03-ны №12/98 дугаартай нэхэмжлэлийг Дорнод аймгийн шүүхэд анх гаргаж байсан. Нэхэмжлэлд 1995 онд “Хэрлэн Хивс” ХК-ны өрийг Австрийн талд төлж барагдуулсан тул тус компанийг төлбөрийн чадваргүй болж дампуурсныг тогтоож өгнүү гэсэн нэхэмжлэл гаргаж байсан нь анхнаасаа компаний өмчийг үшүй хийх сонирхолтой байсан.

Үл хөдлөх хөрөнгийн “Эрдэнэт Хивс” ХК- гэрчилгээг хүчингүй болгосоний дараа Худалдаа хөгжлийн Банканд өмч хөрөнгөө авах талаар хандсан боловч албан ёсны хариу өгөөгүй, хэрлэн сумын Иргэний хэргийн Шүүхэд нэхэмжлэл гаргаж 2006 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн №123 шийдвэрээр ээрэх нэхэхийн конторын барилга конторын барилгын зүүн баруун жигүүрийн 4 хэсэг барилгын, мөн 10 ширхэг нэхэх машины 42,514,212,0 төгрөгийг Худалдаа хөгжлийн Банкнаас гаргуулах шийдвэр гарсан.

Уг шийдвэрийг Худалдаа хөгжлийн Банк давж заалдаж Улсын Дээд Шүүхийн 2006 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн № 284 тогтоолоор дахин шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан.

Улмаар Дорнод аймгийн Иргэний хэргийн 2006 оны анхан шатны шүүхээс 4 ширхэг барилгыг 10ш нэхэх машины 425,142,120 төгрөг гаргуулахаар дахин шийдвэр гарсан. Уг хэргийг ХХбанк Улсын Дээд шүүхэд давж заалдаж 2006 оны 12 дугаар сарын 19-ны №736 тогтоолоор анхан шатны шүүхийн шийдвэрийг Улсын Дээд Шүүх мөн л шалтаг гарган буцаасан.

Хэрлэн сумын шүүхийн 2007 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн № 64 тоот шийдвэр гарч анхан шатны шүүхэд 4 барилга 10ш нэхэх машины 425,142,120 төгрөгийн нэхэмжлэл 3 дахь удаагаа Дорнод аймгийн анхан шатны шүүхэд очиж Худалдаа хөгжлийн Банкны хүссэн ээрэх, нэхэх үйлдвэрийн конторын барилгыг ямар ч үндэслэлгүйгээр “Хэрлэн Хивс” компаний өмчид хууль бусаар халдсан. Улмаар Улсын дээд шүүхийн 2007 оны 06 дугаар сарын 05- ны өдрийн №338 тоот тогтоолоор анхан шатны шүүхийн хууль бус шийдвэр гаргаж 2 ширхэг Ээрэх, нэхэх конторын барилгыг булааж авсан.

Дээрх нөхцөл байдлаас харахад анхнаасаа Монгол Улсад өмч хувьчлалтай холбоотой бизнес хийх, компанийг үнэгүйдүүлж Худалдаа Хөгжлийн банк өөрийн давуу эрх мэдлийг ашиглан өмч хөрөнгөөр бизнес хийх сонирхолтойгоор үйлдвэрийн хөрөнгөнд хууль бусаар халдсан. ХК- ны хуулиар Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг бүх гишүүдийн хурлаар оруулахгүй өмчид халдах ёсгүй.

“Эрдэнэт Хивс” ХК-ны өрийг /Австрийн/ ХХбанк авахдаа бүх хувьцааны 18% ноогдуулсан нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт халдаагүй гэсэн үг юм.

ШШГ Алба өмч хөрөнгийг зах зээлийн үнээр дахин үнэлэх үндсэн хөрөнгийг дуудлага худалдаагаар оруулах, компаний удирдлагыг оролцуулахгүй байх зэрэг хууль бус ажиллагаагаа хийсэн ноцтой алдаанууд харагдаж байна. Ер нь компаний хөрөнгийг “Хэрлэн Хивс” ХК-ны нябо н.Дамидмаа Дорнод аймгийн ШШГА-ны ахлах шийдвэр гүйцэтгэгч Гомбодорж нар хуйвалдан үнэгүйдүүлэх өмч хөрөнгийг жагсаалтаар албан

ёсоор хүлээлгэн өгөөгүйгээс болж өмч хөрөнгө үрэгдсэн. Үүний нэг жишээ бол Хэрлэн сумын 1999 оны 11 сарын 29- ны өдрийн 739 тоот шийдвэрээр 24,144,943 төгрөгийн цахилгааны төлбөрийг Дорнод аймгийн ШШГ Алба 2004 оны 12 дугаар сарын 17-ны өдөр ДЦС-д захиргааны барилгын зүүн жигүүрийг компаний удирдлагад мэдэгдэлгүйгээр шилжүүлсэн хэрэг гарсан. Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК/ төрийн өмчит хувьцаат компани/ шилжүүлсэн актыг 2008 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 02 тоот актаар хүчингүй болгуулсан. Гэтэл ДБЭХС-ын ТӨК 2009 онд нэхэмжлэл гаргаж 2009 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн №446 тоот шийдвэрээр ТӨК- ны нэхэмжлэлийг хүчингүй болгосон. Мөн давж заалдах шатны шүүхээс уг хэргийг 2009 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн № 527 шийдвэрээр анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн. Гэтэл 2009 оны 10 сарын 01- ны өдрийн № 544 тоот шийдвэрээр шүүх нөлөөнд орсон дагуу анхан шатны шүүхээр буцаагдсан. Ингээд нөлөөнд орсон шүүх 2010 оны 02 сарын 05- ны өдөр № 221 тоот Чингэлтэй дүүргийн анхан шатны шүүхээс ДЭХС- ТӨК- ийн талд шийдэж манай өмчид халдсан шийдвэрийг гаргасан. /22 сая төгрөг/ энэ мөнгөнд 2 давхар 1200 метр квадрат талбай бүхий барилга өгөх болсон.

Улмаар Нийслэлийн Давж заалдах шатны 2010 оны 04 дүгээр сарын 06- ны өдрийн № 530 шийдвэр гарч анхан шатны шийдвэрийг хэвээр гаргаж манай өмчийг авах нь тодорхой болсон. Яг энэ шийдвэр гарах үед хавтаст хэргээс “Хэрлэн Хивс” ХК-ны 2004 оны балансыг хуурамчаар үйлдсэнийг мэдэж энэ талаар давж заалдах шатны шүүхэд мэдэгдсэн. Уг 2004 оны балансан дээр тоог засахдаа ШШГА-ны холбогдох хавтаст хэрэгт болон, Дорнод аймгийн татварын хэлтсийн архивт байгаа манай компаний баланс, аймгийн төрийн сангийн архивт хадгалддаг манай баланс зэргийг бүгдийг зассан байсан. Энэ хэргээ далдлах зорилгоор ШШГ Албаны манай компантай холбогдох хавтаст хэрэг бүхэлдээ алга болсон. Энэ эрүүгийн хэрэг үүсгэх хэмжээний гэмт хэргийг илчилснээр Дээд давах, анхан шатны шүүхэд нөлөөлсөн нөлөөллийг үгүй хийсний дагуу Улсын Дээд Шүүхийн хяналтын шатны Иргэний хэргийн шүүхийн 2010 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн № 439 тоот шийдвэрээр нэхэмжлэлийг хүчингүй болгож анх удаа “Хэрлэн Хивс” ХК-ны талд шийдвэр гарсан. Ийм байдлаар олон хавтаст хэрэг алаг болсноос гадна Сангийн Яам, Монгол Банк- нд манай холбогдох хавтаст хэргүүд бүгд алга болсон байдаг. Мөн Австрийн өртэй холбоотой 1998 оны 6 дугаар сарын 18- ны өдрийн Улсын дээд Шүүхийн 98 тоот шийдвэр бүхий хавтаст хэрэг Дорнод аймгийн Шүүхийн архиваас алга болсон. Хэрлэн сумын шүүхийн 2007 оны 03 дугаар сарын 20- ны өдрийн № 64 тоот шийдвэр бүхий хавтаст хэрэг зэрэг манай компантай холбоотой нотлох баримтууд одоог хүртэл алга болж устгагдсаар л байна.

Мөн манай компани й барилгын өмнөх хашаан доторхи газраа одоог хүртэл авч чадаагүй. Мөн л “НОМИН ХОЛДИНГ” ХК шүүхэд нөлөөлсөөр байна.

Дорнод аймгийн Захиргааны хэргийн шүүхээс манай эзэмшил газрыг баталгаажуулж өгсөн боловч Улсын Дээд Шүүхийн хяналтын шатны шийдвэрийг хүчингүй болгож эзэмшил газрынхаа хашаан доторхи газраа авч чадахгүй нийтийн эзэмшилд байсаар байна. Дорнод аймгийн захиргааны хэргийн анхан шатны шүүх газрын тухай 2 удаагийн хуралд биднийг санаатайгаар бидний оролцох боломжоор хангалгүйгээр шүүх хурал хийж бидний эрх ашгийг хохироож байсан.

2011 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн №191 тоот Чингэлтэй дүүргийн анхан шатны шүүхээс 321,321,700 төгрөгийн нэхэмжлэлтэй шүүх хурлын зарыг тулгаж мэдэгдсэнээс 2 удаад нь хойшлуулж, 3 дахь удаа нь манай компанийг оролцуулалгүй шүүх хурлыг хийж нэхэмжлэлийг буцаасан. Шүүх хурлыг хойшлуулахдаа дараагийн шүүх хурлын товыг тухайн хурлаар товийг хэлэлгүй Дорнод аймгийн шуудангаар шүүх хуралдааны товийг 1 хоногийн өмнө тулгаж өгдөг байснаас болж 2 удаа шүүх хуралд

оролцох боломжгүй байгаагаа утсаар мэдэгдэж хойшлуулж байсан. Шүүхэд Шүүх хуралдааны товийг утсаар урьдчилсан мэдэгдэж байх талаар хүсэлт тавьсан боловч уг хүсэлтийг хүлээж аваагүй. Бид “Хэрлэн Хивс” ХК- тай холбоотой бусад шүүх хурлын товийг утсаар урьдчилан мэдэгдэж өмнөх хурлаар шүүх хурлын товийг мэдэгддэг байсан. Харин Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Буянжаргал шүүгч санаатайгаар хуралд оролцох боломжийг хязгаарлаж бидний эрх ашгийг хохироож байсан. Үүнээс болж 2,402,308 төгрөгөөр манай компанийг хохироосон.

Одоо Хэрлэн сумын шүүхийн 2009 оны 04 дүгээр сарын 29- ны өдрийн №19 (а) шийдвэрээр Эвлэрэлийн гэрээ байгуулсан боловч одоог хүртэл гэрээний үүргээ биелүүлээгүй явж ирсэн.

Уг асуудлаар удаа дараа ШШГ Албанд хандсан боловч “Номин Холдинг” ХХК нь төрийн шийдвэрийг үл хүндэтгэх, ШШГА – ны ажилтанг хэл амаар доромжлох өгөгдсөн үүрэг даалгавар биелүүлэхгүй төрийн шийдвэрийг уландаа гишгэсээр өнөөг хүрлээ.

Бид 2011 он хүртэл Худалдаа хөгжлийн Банк “Номин Холдинг” ХК- аас Хивсний үйлдвэрийн үлдсэн гэх өөрийн хөрөнгөө нэхэмжилж байсан. Тухайн үед бид Худалдаа хөгжлийн Банк компаний бүх өмчийг хамгаалалтандаа авсан цаашид хамтарч ажиллана гэж ойлгож өмчөө нэхэмжилж байсан. Энэ талаар Дорнод аймгийн ШШГ Алба мөн Худалдаа хөгжлийн Банканд манай компаний бүх хөрөнгө хамгаалалтанд очсон гэж хариу өгч байсан. Гэтэл Дорнод аймгийн ШШГ Алба манай өмчийг битүүмжилж хурааж өмчийг албан ёсоор хүлээлгэж өгөөгүй учир бид ШШГА-нд өмч хөрөнгөө хүлээж авах талаар 2011 оны 8 сараас хандаж эхэлсэн. Улмаар Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газар, Хууль зүйн Яам, Санхүүгийн зохицуулах хороонд тус тус албан ёсоор хандаж улмаар Хэрлэн сумын Шүүхэд өмч хөрөнгөө хүлээж авах талаар 2017 онд нэхэмжлэл гаргасан.

2017 оны 04 дүгээр сарын 14-ны Хэрлэн сумын Давж заалдах шатны шүүхийн №201/МА 2017/00017 тоот магадлал гарч Иргэний хуулийн дагуу хөөн хэлэлцэх хугацааг сэргээсэн нотлох баримтыг өгч цаашид шүүхдэх боломжтой гэсэн шийдвэр гарсан. 2015 оны 03 дугаар сарын 02 ны өдрийн Б-30 дугаартай хариу албан бичигт “Голден Пейж” аудитын компанд “Хэрлэн Хивс” балансад аудит хийлгэх хуулийн дагуу хандсан боловч: Аудит хийх боломжгүй танай компаны хөрөнгө ШШГА-нд хураагдсан, өмч хөрөнгө тодорхойгүй тул аудит хийх боломжгүй гэсэн хариу өгсний дагуу Иргэний шүүхээр нотлох баримтаа цуглууж явж байна.

2005 онд “Эрдэнэт Хивс” ХК 2004 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн № 2030314 20/121 V- 0611003485 үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээнд 190* 375 хэмжээтэй 7 га талбай бүхий объект эд хөрөнгийн хашаа бүхэлд нь авсан байсныг Захиргааны шүүхээр хүчингүй болгож бага боловч өмч хөрөнгө үлдэх эрхийг үүсгэсэн.

2005 оноос тус компаний гүйцэтгэх захиралаар Д. Ганцогт миний бие ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар 1999 оны 12 дугаар сарын 30- ны өдрийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн баримтаас харахад 4 барилга үлдсэнээс шүүхийн журмаар Худалдаа хөгжлийн банк буюу “Номин ХХК”-л 2 барилга алдагдсан. “Хэрлэн Хивс” ХХК-д 2 барилга буюу 1200 мкв талбай бүхий барилга үлдсэнээс захиргааны барилгын баруун жигүүр буюу 600 мкв талбай бүхий барилгыг 2018 он хүртэлх “Хэрлэн хивс”- ХК-наас урсгал зардал, цалин хөлс, шүүхийн үйл ажиллагааны зардлын тооцоонд шилжүүлж 600 мкв талбай бүхий байр үлдээд байна.

Одоог хүртэл 2004 оноос хойш өмчийн асуудлаар Шүүхийн Шийвэр гүйцэтгэл, шүүхээр шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

Дээрх нөхцөл байдлаас Төр буюу тухайн үед төрийн банк байсан ХХБанк, Шүүхийн Шийдвэр гүйцэтгэл, Шүүхийн оролцоотой шунахай сэдлээр хөрөнгийн

195хувийг\ шамшигдуулсан гэж хэлж болно. Энэ асуудлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хууль бус үйл ажиллагааг Авилгалтай тэмцэх газарт, "Номин реалитор "ХХК ийг ТЕХТИМА -4312 маркийн 10 ширхэг нэхэх машиныг тонох, сууриар нь ачиж явсан асуудлаар цагдаад хандаад байна.

2020-2021ОНД ХИЙГДСЭН ГОЛ АЖИЛ, ТУЛГАМДАЖ БУЙ БЭРХШЭЭЛ

1998 оны 6 сарын 18-ны өдрийн №98 тоот шийдвэр, Хэрлэн сумын шүүхийн 2007 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн № 64 тоот шийдвэр, Хэрлэн сумын шүүхийн 2009 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн №19 (а) шийдвэрээр Эвлэрэлийнн гэрээ зэрэг хэргүүдийн гүйцэтгэлийн ажиллагаа дуусгавар болгож чадахгүй "Номин Холдинг" ХХК-ны нөлөөнд орж 10 гаруй жил болсон. Дээрх 3 хэргийг Авилгалтай тэмцэх газарт өгч шалгуулснаар Хэрлэн сумын шүүхийн 2007 оны 03 сарын 20-ны өдрийн № 64 тоот хэргийг **Дорнод аймгийн ШШГазар 2021 оны 01 дүгээр сарын 20-ны гүйцэтгэлийн ажиллагааг дуусгавар болгож өөрийн эзэмшлийн өмч хөрөнгөндөө анх удаа орох эрхээ авсан.** 1998 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн № 98 тоот шийдвэрийн гүйцэтгэлийн ажиллагааг дуусгахгүй компаний өмчөө хүлээн авалгүй байсаар **2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Дорнод аймгийн ШШГГазраас бүх хөрөнгийг хураан авч битүүмжилсэн хөрөнгөөс үлдсэн хөрөнгөө хүлээж авлаа.**

Үлдсэн хөрөнгө хүлээж авахад тус компаний эзэмшлийн хашааг буулгаж авч явсан, компаний баруун талын цементэн хашаа бүхий 3 га газрыг хууль бусаар луйвардан авсан нь нотлох баримтаар олдлоо. Энэ талаар холбогдох хуулийн байгуулага болох Цагдаагийн байгууллага болон орон нутгийн захиргааны байгууллагад хандаад байна. 2018 онд хариуцагч "Номин Холдинг ХХК", "Номин реалитор "ХХК нь "ТЕХТИМА -4312" маркийн 10 ширхэг нэхэх машиныг тонож, сууриар нь ачиж 800 гаруй сая төгрөгийн хохирол учруулж хуйвалдаад одоог хүрлээ.

2009 оны Хэрлэн сумын сум дундын шүүхийн 19/А Эвлэрэлийн гэрээнтэй холбоотой шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг хийж дууссан. 2018 онд нэхэх ТЕХТИМА-4312 маркийн 10 ширхэг машины эд анги алдагдсан гомдол одоог хүртэл шийдэгдээгүй явж байна. "Хэрлэн Хивс" ХК-ны баруун талын ногооны цементэн хашаатай холбогдох хэргийг Дорнод аймгийн Хэрлэн сумын Иргэний хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргаад явж байна. "Дорнод Худалдаа" ХХК-ны нэхэмжлэлтэй иргэний хэрэгт хариуцагчаар "Хэрлэн Хивс" ХК оролцоод 24 сая төгрөгийн хуурамч материалтай холбоотой сөрөг нэхэмжлэлийг гаргаад нэхэмжлээд явж байна.

"Номин реалитор"ХХК -тай холбогдох "Хэрлэн Хивс" ХК-ны үйлдвэрийн захиргааны барилгын зүүн, баруун жигүүрийн дулаан, цахилгааныг төвийн шугамтай холбох гомдолыг УБ хот, Хан- Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргаад явж бна. Энэ хэрэгт хариуцагчаар "Номин реалтор" ХХК байгаа.

Тус компани нь үйл ажиллагаа явуулаагүй улмаас "Х" тайлан гаргаад явж байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.ГАНЦОГТ